

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

**Асуулт:** Монгол Улс 2013 онд хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйтэй холбоотой өөрчлөлтүүдийг хийсэн. Үүний гол ач холбогдол юу байв?

**Хариулт:** Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг сайжруулах, хөрөнгө оруулагчдад нийтлэг эрх зүйн баталгаа олгох, хөрөнгө оруулагчийн эрх, эд хөрөнгийг хамгаалах, албадан хураахгүй байх, ялгаварлахгүй байх, дэмжих, татварын орчинг тогтворжуулах замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээ, бүртгэлийг хөнгөвчлөх чиглэлээр “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийг Монгол Улсын Их Хурлаас батлан 2013 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

Энэхүү шинэ хуультай холбогдуулан хуучин “Гадаадын хөрөнгө оруулалтын газар”-аас зөвшөөрөл авдаг зохицуулалт байхгүй болсноор Хөрөнгө оруулагч та Улсын бүртгэлийн гэрчилгээгээ УБЕГ-аас авч үйл ажиллагаагаа эхлүүлэх боломжтой болсон.

**Асуулт:** Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчны тогтвортой байдлын баталгаа ?

**Хариулт:** Гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс Монгол улсыг хууль эрх зүйн орчны хувьд тогтворгүй, шинэ УИХ, Засгийн газар гарч ирээд хуулиа өөрчилдөг гэсэн шүүмжлэл байдаг байсан.

Бид Хөрөнгө оруулалтын шинэ хуулиараа энэхүү хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэхээр тусгасан нь хууль эрх зүйн орчин тогтвортой байх томоохон баталгааг өгч чадсан.

**Асуулт:** Хөрөнгө оруулалтын эрсдлийн талаар ?

**Хариулт:** Монгол Улс Дэлхийн банкны Олон талт хөрөнгө оруулалтын даатгалын агентлагийн гишүүнээр элссэн тул хөрөнгө оруулагчид тус агентлагаар эрсдлээ даатгуулах боломжтой юм.

**Асуулт:** Хөрөнгө оруулалттай холбоотой Олон улсын гэрээ конвенцын талаар?

**Хариулт:** Монгол улс Гадаадын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчны хувьд нээлттэй, таатай орон бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсын Засгийн газар 29 улстай “Давхар татвараас чөлөөлөх тухай хэлэлцээр”-ийг, 24 улстай “Худалдаа эдийн засгийн ерөнхий хэлэлцээр”-тэй, 42 улстай “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай” хоёр талт хэлэлцээрийг байгуулаад байна.

Эдгээр гэрээ, хэлэлцээр, конвенцид нэгдэн орсноор Монгол Улс Олон улсын өмнө гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, баталгаажуулахад чиглэсэн тодорхой үүрэг, хариуцлага хүлээж байгаа хэрэг юм.

**Асуулт:** Монгол Улсын компанитай холбоотой татварын төрлүүд, хувь хэмжээний талаар ?

**Хариулт:** Монгол Улс Азийн бүс нутагтаа хамгийн бага татвартай орны тоонд ордог бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдыг татах, дэмжих, урамшуулах томоохон хүчин зүйл

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР**

болж байдаг ба Та хүсвэл хууль эрх зүй, татварын орчныг тогтвортой байлгах гэрээ хийх боломжтой юм.

Нийт 17 төрлийн татвар байдгаас экспортын албан татвар -0%, НӨАТ -10%, орлогын албан татвар /3 тэрбум төгрөг хүртэл/ - 10%, түүнээс дээших хэсэгт 25% гэх мэт байна.

**Асуулт:** Шинэ Хөрөнгө оруулалтын хуулиар татварын хувь, хэмжээг тогтворжуулах, гэрчилгээ авах боломжтой болсон гэсэн. Энэ талаар тодруулмаар байна?

**Хариулт:** Хөрөнгө оруулагч татварын хувь хэмжээнээс илүүтэй тогтвортой байдлыг илүүд үзэж чухалчилдаг. Тиймээс шинэ Хөрөнгө оруулалтын хуулиар Тогтворжуулах гэрчилгээ олгох замаар хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх аж ахуйн нэгжийн орлогын албан татвар; гаалийн албан татвар; нэмэгдсэн өртгийн албан татвар; ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг татварын хувь, хэмжээг тогтворжуулах боломжтой болсон.

**Асуулт:** Монгол Улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ хийх боломжтой юу ?

**Хариулт:** Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломжтой болсон.

**Асуулт:** Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж /ГХОААН/-ийг хэрхэн байгуулах, бүртгүүлэх вэ? Үе шатын талаар тайлбар өгнө үү ?

**Хариулт:** Хөрөнгө оруулагч та “Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль”-д заасан бичиг баримтыг бүрдүүлэн УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хандан “Улсын бүртгэлийн гэрчилгээ”-г авснаар албан ёсоор үйл ажиллагаа эрхлэх боломжтой.

**Асуулт:** Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг хэрхэн байгуулах вэ?

**Хариулт:** Хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалт хийхийн өмнө зах зээлээ судлах, түншээ олох зэргээр бэлтгэл ажлууд хийх зорилгоор эрх зүйн төлөөллийн эрх бүхий өөрийн Төлөөлөгчийн газраа байгуулах боломжоор Монгол улс хангаж байна. Та “Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль”-д заасан бичиг баримтыг бүрдүүлэн УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хандан “Төлөөлөгчийн газрын гэрчилгээ”-г авснаар албан ёсоор үйл ажиллагаа эрхлэх боломжтой.

**Асуулт:** Гадаадын хөрөнгө оруулагч Монгол Улсад эрхлэхийг хориглосон үйл ажиллагаа бий юу?

**Хариулт:** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах; садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих; казиногийн үйл ажиллагаа эрхлэх; олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа эрхлэхийг тус тус хориглодог.

- Асуулт:** Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэж?
- Хариулт:** Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг хэлнэ.
- Асуулт:** Гадаадын хөрөнгө оруулалтыг тодорхой салбаруудад 33 хувиас дээш эзэмшихийг хориглосон заалт бүхий хууль байгаа гэх юм. Энэ талаар хариулт өгнө үү ?
- Хариулт:** “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах хууль”-ийг 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр хүчингүй болгосон.  
Хэдий хууль хүчингүй болсон ч хүчин төгөлдөр байхдаа ч хөрөнгө оруулагчийн эзэмших хувь хэмжээг хязгаарласан, хориглосон заалт байгаагүйг дурьдмаар байна.  
“Хөрөнгө оруулалтын хууль”-д зөвхөн гадаадын төрийн өмчит хуулийн этгээд нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувь хэмжээг эзэмших тохиолдлыг нягтлан зөвшөөрөх талаар зохицуулалт орсон.  
Та [www.investmongolia.com](http://www.investmongolia.com) веб хуудаснаас хуультай танилцах боломжтой.
- Асуулт:** Гадаадын хөрөнгө оруулалттай компани байгуулах, бүртгүүлэхэд шаардагдах хугацаа ?
- Хариулт:** Хуулийн этгээдийн бүртгэлийн газар ГХОААН байгуулахад ажлын 10 хоног дотор багтаан шийдвэрлэнэ. Энэхүү хугацааг ахин багасгах талаар ажиллаж байна.
- Асуулт:** Гадаадаас хөрөнгө оруулсан болохоо хэрхэн батлах вэ ?
- Хариулт:** Гадаадын хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтыг мөнгөн хөрөнгөөр хийж байгаа бол гадаад улсаас мөнгөн хөрөнгө шилжүүлснийг нотолсон банкны дансны хуулга, тодорхойлолтыг хавсаргана.
- Асуулт:** Заавал бэлэн мөнгөөр хөрөнгө оруулалт хийх шаардлагатай юу?
- Хариулт:** Үгүй. Та өөр эх үүсвэрээр буюу хөдлөх эд хөрөнгөөр хийж байгаа бол гаалийн байгууллагын мэдүүлэг, оюуны үнэт зүйлээр хийж байгаа бол тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон гэрчлэх баримт бичиг зэргээр хийж болно.